

**АХУЙН ХОРТОН ШАВЬЖ, МЭРЭГЧ УСТГАЛЫН БОЛОН АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИСЫГ
УЛСЫН ХИЛЭЭР ИМПОРТЛОХ ҮЕД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ХУУЛИЙН ҮНДЭСЛЭЛ**

№	Дагалдах баримт бичиг		Хууль тогтоомж, стандартын заалт	Баримт бичигт тавигдах шаардлага	ААНБ-аас материал авах давтамж
	Нэр	Ямар байгууллагаас олгох			
1	Улсын бүртгэлд бүртгэгдсэн байх	-	Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам	БОНХАЖС, ХХААС, ЭМС-ын тушаалаар жил бүр шинэчлэгдэн батлагддаг ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалтад орсон байх	-
2	Ариутгал, халдваргүйтлийн бодис ашиглах, худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	ЭМЯ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 15.12.8	-Эх хувь	Хуулбарыг импортлох тухай бүр
3	Химийн хорт болон аюултай бодис импортлох тусгай зөвшөөрөл	БОНХЯ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 15.6.3, 15.6.7, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 15.4, Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 2.1.3.6, 2.1.3.7	-Эх хувь	Хуулбарыг импортлох тухай бүр
4	Гарал үүслийн эсвэл чанарын гэрчилгээ	Экспортлогч талын эрх бүхий байгууллага	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 2.1.3.2	-Эх хувь	Импортлох тухай бүрд
5	Хор аюулын лавлах мэдээллийн хуудас	Үйлдвэрлэгч	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль 6.1, Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 2.1.3.3, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 стандарт 3.5, 8.4	-Хуулбар хувь -Монгол хэл дээр орчуулсан байх -Үйлдвэрлэгч нь боловсруулсан байх -Стандартад заасан зайлашгүй байх шаардлагатай мэдээллийг агуулсан байх -Тухайн баримт бичигтэй тээврийн хэрэгслийн жолооч болон дагалдан яваа хүмүүс танилцсан байх	Импортлох тухай бүрд шаардах ба тухайн баримт бичиг нь ачаа, барааг дагалдаж яваа эсэхийг шалгаад аж ахуйн нэгж, байгууллагад буцааж өгнө
6	Худалдааны гэрээтэй	-	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох,	-Эх хувь	Тухайн гэрээний хугацаанд 1

			хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 2.3.1		удаа
7	Тээврийн гэрээ (автозам), гэрээнд холбогдох мэдээллийг хавсаргасан байх	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгаль орчны болон гамшгаас хамгаалах улсын байцаагчаар хянуулсан	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам 3.1.1.3, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 3.1.1.2, 3.1.1.3 3.3.15, 3.3.8, Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам 2.3.5	-Гэрээ Эх хувь, -Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгаль орчны болон гамшгаас хамгаалах улсын байцаагчаар хянуулсан байх -Тээвэрлэгч байгууллага, жолооч болон дагалдан яваа хүмүүст танилцуулан гарын үсэг зуруулж, гэрээнд хавсаргасан байх	Гэрээг тухайн гэрээний хугацаанд 1 удаа, Аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг импортлох тухай бүр шаардах ба тухайн баримт бичгүүд нь ачаа, барааг дагалдаж яваа эсэхийг шалгаад аж ахуйн нэгж, байгууллагад буцааж өгнө.

Нэмэлт мэдээлэл: Химийн хорт болон аюултай бодисыг Засгийн газрын 2006 оны 296, 2007 оны 65, 2010 оны 203 тоот тогтоолоор тус тус батлагдсан Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Сүхбаатар, Дорнод аймгийн Баянхошуу, Сүхбаатар аймгийн Бичигт, Чингис хаан” олон улсын нисэх буудлын хилийн шалган нэвтрүүлэх боомтоор тус тус нэвтрүүлнэ.

Химийн хорт болон аюултай бодисыг импортлоход дээрхи баримт бичгийг бүрдүүлэхээс гадна зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, зориулалтын баглаа, боодолд савласан байх, хаяг шошго Англи, Монгол, Орос хэлний аль нэг хэл дээр үйлдэгдсэн байх, хаяг шошго нь шаардлагатай мэдээллийг агуулсан байх, тээврийн хэрэгсэл болон сав, баглаа боодол дээр хор, аюулын анхааруулах тэмдгийг тавьсан байх зэрэг шаардлага тавигдана. Эдгээр шаардлагыг № 9.4.1.1, 9.4.1.2 кодтой Химийн хорт болон аюултай бодисыг импортлох үеийн хяналтын хуудас болон “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”, “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”, “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011 стандарт”-аас харна уу.